



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 4/33

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд
зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн улсын чанартай авто замаар Ховд аймаг руу нийтийн тээврээр дамжин өнгөрсөн иргэдийн дунд коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн хилийн зааг болох Архангай аймгийн Хашаат сумын Тарны гүүрэн дээр байнгын хяналтын цэгийг төвлөрүүлж, үйл ажиллагааг сайжруулан, голомтот бүс нутгаас ирж байгаа иргэдэд эрүүл мэндийн хяналт хийх, бүртгэх, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэг ажиллуулах, тусгай зөвшөөрлийн QR кодыг шалган нэвтрүүлж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Хархорин сумын Засаг дарга (Ч.Алтанбагана) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсэнтэй холбогдуулан Улаанбаатар хотоос тус аймгийн Бүрд сумыг дамжин өнгөрч Баян-Өндөр, Есөнзүйл, Сант сумд руу зорчих замд түр хяналтын цэгийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж ажиллахыг дээрх сумын Засаг дарга нарт даалгасугай.

3.Худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд Улаанбаатар хотоос хүнс, бараа материалын ачаа тээвэр захиалан ирүүлэхдээ Онгийн голын хяналтын цэг дээр аймгийн шуурхай штабт бүртгүүлэн, халдвар хамгааллын дэглэм мөрдөж ажиллах баталгааг гаргасны дараа ачааг буулгах тухайн тээврийн хэрэгслийг хяналтын цэгээр буцаан гаргах чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Халдвар хамгааллын дэглэм зөрчиж, үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоож, хариуцлага тооцохыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн) нарт үүрэг болгосугай.

0111000930

2.

5.Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 01 дүгээр сарын 28-ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хориглож, лацдах ажлыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн) нарт даалгасугай.

6.Улсын чанартай төв автозам дагуу хоол үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс түр зогсоохыг Арвайхээр, Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Тарагт, Хайрхандулаан, Нарийнтээл сумын Засаг дарга нарт даалгасугай.

7.Шатахуун түгээх станцуудын нийтийн эзэмшилийн талбайг стандартын дагуу камержуулан, ажилтнуудыг халдвар, хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8.Бүх шатны гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумын Засаг дарга нарт даалгасугай.

9.Голомтот бүс нутгаас ирж, гэрийн ажиглалтад орсон иргэдэд хяналт тавих ажлыг эрчимжүүлж, хамтран ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), мэргэжлийн анги, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

10.Арвайхээрээр баруун чиглэлд төвөөр дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийг хөтөч машинаар хөтлөн, өнгөрүүлэх ажлыг зохион байгуулахыг мэргэжлийн ангийн дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

